

## **ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 02 ДУГААР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

### **Нэг. Нутгийн удирдлага зохион байгуулалтын талаар:**

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа хуралдаж 9 асуудал хэлэлцэж, 6 асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр, 1 асуудлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт уламжлахаар тус тус шийдвэрлэв.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг дарга 13 өргөдөл бичгээр хүлээн авч, 10 өргөдлийг шийдвэрлэж, 3 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж байна. Төрийн албаны салбар зөвлөл 1, Засаг даргын Тамгын газар 5 өргөдөл бичгээр хүлээн авч, 4 өргөдлийг шийдвэрлэж, 1 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа хүлээгдэж нийт өргөдлийн шийдвэрлэлт 78.9 хувьтай байна.

Иргэдээс 7 сувгаар мэдээлэл хүлээн авах 7043-1111 төвд 2 сувгаар 11 мэдээлэл хүлээн авахад дуудлагаар 9, биечлэн 2 иргэн санал, гомдол, шүүмжлэл ирүүлснээс гомдол 5, санал хүсэлт 5, шүүмжлэл 1 тус тус бүртгэж холбогдох хэлтэс, тасгийн дарга нарт шилжүүлж, 10 иргэний санал хүсэлт, гомдолд хариу өгч шийдвэрлэн, 1 санал хүсэлт шийдвэрлэгдэхээр хүлээгдэж шийдвэрлэлт 90,9 хувьтай байна. Орчны эрүүл ахуйн чиглэлээр 2, халаалт дулаан 3, бусад 6 санал хүсэлт хүлээн авсан байна.

Иргэдээс Монгол улсын Их хурал, түүний өргөдлийн байнгын хороонд хандан гаргасан өргөдөл бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын 1111 төвд ирсэн 5 санал хүсэлт, 5 гомдол хүлээн авч холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж 3 санал хүсэлт, 5 гомдлыг шийдвэрлэн хариу өгч, 2 санал хүсэлт шийдвэрлэлтийн шатандаа хүлээгдэж байна.

### **Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн талаар:**

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 2 дугаар сард улсын төсвөөс авах санхүүжилт бүрэн хийгдэж, цалин хөлс, тогтмол зардал, зарим зайлшгүй гарах зардлуудыг хянаж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгов.

Сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга нарт 2016 оны төсвийн гүйцэтгэл, 2017 оны төсвийг танилцуулж, цаашид авах арга хэмжээний талаар чиглэл өглөө. Төсвийн “Fiscal” программд шинэ зориулалт болон эдийн засгийн ангилал нэмэгдсэн өөрчлөлтийг Сангийн яамнаас ирүүлсэн зааврын дагуу төрийн сангийн мэдээнд хийв. Мөн орон нутгийн хөгжлийн сангаас урсгал зардлыг санхүүжүүлдэг болсонтой холбогдуулан “Орон нутгийн хөгжлийн сан” гэсэн шинэ төсвийн төрөл нэмэгдсэн бөгөөд уг төсөв дээр зөвхөн ОНХС-аас санхүүжиж буй зардлуудыг

шивж оруулав. Төсвийн 2016 оны 2 дахь тодотголын төлөвлөгөөг сум, байгууллагаас авч нэгтгэн Сангийн яаманд 1/458 дугаар албан бичгээр хүргүүлээ.

Аж ахуйн нэгжийн 2016 оны жилийн эцсийн тайланг 1280 байгууллагаас хүлээн авч, баталгаажуулалтын ажил 80 хувьтай хийгдэж байна. Аймгийн төвийн төрийн сангаар 416 ширхэг зардлын ваучер бичигдэж 2.8 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээ гарсан байна. Орон нутгийн төсвийн 1 дүгээр сарын гүйцэтгэл болон өр, авлагын мэдээг нэгтгэн гаргаж удирдлагад танилцуулан Сангийн яаманд сүлжээгээр дамжуулж, мэдээллийн самбарт байршууллаа. 1 дүгээр сарын байдлаар аймгийн нийт өр 306,3 сая, авлага 3750,8 сая төгрөг байна. Авлагын дийлэнх 3291,5 сая төгрөг буюу 88 хувь нь сум хөгжүүлэх сангийн авлага байна. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон аймгийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний санхүүжилтэнд 200,7 сая төгрөг олгов.

Татварын хэлтэс 2016 оны жилийн эцсийн байдлаар 228 иргэний хувь хүний орлогын албан татварын тайланг, 1472 аж ахуйн нэгжээс ААНОА-ын тайланг хүлээн авч 89.2 хувьтай суутган, 1309 тайлан хүлээн авахаас 1130 тайлан хүлээн авч 86.3 хувьтай, НӨАТ-ийн 354 тайлан хүлээн авахаас 354 тайлан хүлээн авч өссөн дүнгээр 100 хувьтай, суутгагчийн хувь хүнээс суутгасан 301 тайлан тус тус хүлээн авч, 94 татвар төлөгчид лавлагаа тодорхойлолт гарган, виз хүссэн 2, зээл авах 42, эрх шилжүүлэх 1, зөвшөөрөл сунгах 1, тендэрт оролцох 3, бусад 35 хүсэлтийг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэв.

### **Гурав. Хууль эрх зүйн салбарын хүрээнд:**

Аймгийн хэмжээнд ХАСХОМ гаргах эрх бүхий 271 албан тушаалтны мэдүүлгийг цахимаар хүлээн авч цахим болон цаасан бүртгэлд бүртгэж гарын үсэг зуруулан баталгаажуулав. Захирамж, тушаал хянах хуваарийн дагуу Алтай, Булган сумдын захирамж, тушаалын хууль тогтоомжийн үндэслэл, архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангасан байдал, хамаарал бүхий этгээдтэй холбоотой шийдвэр гаргасан эсэх талаар хянан дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлэв.

**Цагдаагийн газар:** Ховд аймгийн хэмжээнд 2017 оны 02 дугаар сарын 24-ний байдлаар 23 гэмт хэрэг бүртгэгдсэнээс бусдын бие махбодид гэмтэл учруулах 15, хулгайлах 11, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэрэг 3, бусдыг амиа хорлоход хүргэсэн 1, танхайрсан 1, бусдын эд хөрөнгийг завшиж үрэгдүүлсэн 1, захиргааны журмын эсрэг 1 гэмт хэрэг тус тус бүртгэгдсэн байна. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас Цагдаагийн газар 365 гомдол мэдээлэл хүлээн авч, 98 буюу 27.0 хувийг гэмт хэргийн, 266 буюу 73.0 хувийг захиргааны зөрчлийн, 1 буюу 0.1 хувийг бусад гомдол мэдээлэл эзэлж байна. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон 15 гомдол, мэдээлэл байна. Зөрчил

гаргасан 110 хүнийг албадан саатуулж, 1382 хүнийг 51.515.100 төгрөгөөр торгох арга хэмжээ авч ажиллав.

Жаргалант сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 46 байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгчид, алба хаагчдад болон Хөгжил-политехник коллежийн багш ажилчид, оюутнууд нийт 201 хүнд байгууллагын 2016 оны тайлангаа танилцуулж санал хүсэлтийг сонсов. Аж ахуйн нэгжүүдийн харуул хамгаалалтыг шалгаж камержуулах, олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг сайжруулах, нийтийн хэв журам сахиулах, иргэдэд хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон Тамхины хяналтын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, тухайн хуулиудыг сурталчилах зорилгоор аймгийн **МХГ-ын улсын байцаагчид болон олон нийтийн цагдаагийн ажилтнуудтай хамтран үзлэг шалгалт зохион байгуулж 3 аж ахуйн нэгжээс хугацаа нь дууссан 33 шил пиво, тамхи ширхэглэн зарсан 1 аж ахуйн нэгжээс 12 ширхэг тамхи хураан авч холбогдох газарт нь хүлээлгэн өгөв.**

**Шүүхийн шинжилгээний алба:** Албаны 2016-2017 оны Сургалтын төлөвлөгөө болон Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу алба хаагчдын дунд 4 сэдвээр 6 цагийн сургалт, спортын арга хэмжээг 2 удаа зохион байгуулж чөлөөт цагийг зүй зохистой үр дүнтэй өнгөрүүлэв.

Шүүх эмнэлгийн бүтцийн шинжилгээг 4 цогцост, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийг 43 хүнд, химийн шинжилгээ 6, биологийн шинжилгээ 5, кримналистикийн шинжилгээ 16 тус тус хийж, 74 дүгнэлт гаргаж, алсын дуудлаганд кримналистикийн шинжээч, шинжээч эмч, туслах ажилтан нар 3 удаа явж үүрэгт ажлаа биелүүлэв.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба:** Хорих ангийн харуул хамгаалалтыг "Хорих ангийн харуул хамгаалалт болон ялтанд хяналт тавих журам"-ын дагуу зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд албаны даргын тушаалаар онцгой үед ажиллах төлөвлөгөөг сар бүр шинэчлэн батлуулж, алба хаагчдад танилцуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Болзошгүй ажиллагааны үед ашиглагдах тээврийн хэрэгслийн бэлэн байдал, гал унтраах багаж хэрэгсэл, нөөц цахилгаан үүсгүүр, гар чийдэн, гэрлийн шил, бэлэн байдлын түлшний талон зэргийг тогтмол шалган бүртгэлээр хүлээлцэн алба хаагчдад үүрэг чиглэл өгч биелэлтэнд хяналт тавьж ажиллалаа.

Ангийн байрлалаас 45 км-т байрлах малын хэсэгт 1 хянагчийн хяналтанд нэр бүхий 2 ялтныг ажиллуулж, эргэн шалгах төлөвлөгөөний дагуу шалган нэмэлт үүрэг даалгавар өгч байнгын хяналт тавьж байна. Албаны үйл ажиллагаа хууль журмын дагуу хэвийн явагдаж байгаа бөгөөд ялтан, хоригдогч нарын дундаас ямар нэгэн гэмт хэрэг зөрчилгүй тайван байгаа болно.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** Энэ сард нийт 3450 иргэнд үйлчилгээ үзүүлж ажилласнаас Иргэний бүртгэлийн чиглэлээр 2583, аймгийн хэмжээнд шилжих хөдөлгөөнд хамрагдсан 771 иргэнээс шилжин ирсэн иргэд 80, шилжин явсан иргэд 101, аймаг доторх сумаас суманд, багаас багт шилжсэн 590 иргэн байв. Гадаад паспортын олголт болон сунгалт 433, иргэний үнэмлэх шинээр олголт 195, сунгалт 236, дахин олголт 149, иргэний бүртгэлийн лавлагаа 529 иргэнд тус тус олгож, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн 270 бүртгэлийг хийв.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 571, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 108 иргэнд тус тус холбогдох үйлчилгээг үзүүлж, иргэдээс 8 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч 3 өргөдөлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 3 өргөдлийг холбогдох байгууллагад шилжүүлж, 2 өргөдлийн хугацаа болоогүй байна.

### **Дөрөв.Нийгмийн бодлогын салбарын хүрээнд:**

**Боловсрол соёлын чиглэлээр:** 2 дугаар сард хийх ажлын төлөвлөгөөний дагуу Ховд, Эрдэнэбүрэн, Дуут, Мянгад, Дөргөн сумын сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагуудын ажилтай танилцаж арга зүйн зөвлөгөө өгч, 142 цагийн хичээл, үйл ажиллагааг ажиглаж, мэргэжлийн шалгалтад 104 багш, хөндлөнгийн үнэлгээнд 756 сурагчид хамрууллаа.

“Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь” төслийн үйл ажиллагаа манай аймгийн 7 сумын 10 сургуулиудад хэрэгжиж байна. Тус сургуулиуд хамтран ажиллах төлөвлөгөө гарган, төслийн нэгжийн захиргаанд холбогдох баримт бичгийг хүргүүлэв.

Ерөнхий боловсролын сургуулиудын захирал, цэцэрлэгийн эрхлэгч, нарын дунд сургалт хийж, боловсролын талаар баримтлах бодлого, чиглэл, цаашид анхаарах асуудлуудын талаар хэлэлцлээ. Сургалтад сургуулийн захирал, эрхлэгчид хамрагдав. Боловсрол, соёлын салбарын хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж эхний шатны хэлэлцүүлгийг зохион байгуулан “Чадварлаг Ховдчууд”, “Олон үндэстэн угсаатны өв соёл” дэд хөтөлбөрийг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр төслийг өргөн мэдүүлсэн.

Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн II шатны төсөл хэрэгжиж байгаа Жаргалант сумын 1, 2, 6 дугаар сургууль, Ховд, Эрдэнэбүрэн, Мянгад сумын сургуулиудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв.

Монголын залуу багш нарын холбооны Ховд аймаг дахь салбарыг байгуулан Тэргүүлэгчдийг сонголоо. Тус хуралд аймгийн төвийн сургуулиудын залуу багш нарын төлөөлөл 134 багш оролцов.

“Журамласан үгийн толь бичиг”-т тусгах Монгол хэл-Уран зохиолын багш нарын саналыг нэгтгэн үндэсний зөвлөлийн ажлын албанд хүргүүлэв.

2017 оны Алтан унжлагат хэмээх гал тахиа жилийн сар шинийн баярыг угтан Монголын үндэсний олон нийтийн радио телевизтэй хамтран сар шинийн нар угтах, шинийн нэгний золголтын нэвтрүүлэгийг хийж, тус нэвтрүүлэгт аймгийн удирдлагууд, ахмадууд, гавьяатууд оролцож олон үндэстэн ястны урлагийн мэндчилгээг өргөн барилаа. Мөн “Эргэх 4 цаг” цаг үеийн мэдээллийг бэлтгэн Цэцэг, Мөст сумдын улсын аварга болон аймгийн аварга малчин айлд зочлов. “Наран хөвүүн хаан” туулийг бүрэн эхээр нь хайлах ёслолын арга хэмжээ болж соёлын биет бус өвийн бүртгэл мэдээллийн санд бүртгэгдэж Ховд телевиз болон аймгийн Музейн бүртгэл мэдээллийн санд хадгалагдав.

Аймгийн Хөгжимт драмын театр 2 дугаар сард 10 үйл ажиллагаа зохион байгуулан 2250 үзэгчдэд соёл урлагийн үйлчилгээ үзүүлсэн төдийгүй валентины баярын “Гэгээн хайр” концерт тоглогдов.

Аймгийн Музей нь үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулахад анхаарч үзүүлэгийн танхимын үзмэрүүдийн дэлгэлтийг өөрчлөн, үзмэрийн арын фоныг солив. Мөн “Монголчуудын шинэлэх ёс” сэдэвт ардын уламжлалт ёс заншлыг харуулсан тэмцээнийг Жаргалант сумын 7 дугаар дунд сургуультай хамтран зохион байгууллаа.

Нийтийн номын сан 267 уншигчдад карт нээж 3341 ирцэд 4312 ном, сонин хэвлэл олгон, Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон албан байгууллагуудын албан хаагчид, сумын иргэдийн дунд уралдаан тэмцээнийг 4 удаа, номын үзэсгэлэн 8, номын өдөрлөг 4, сургалт мэдээлэл 8, тойм яриа 1, нээлттэй хаалганы өдөр 4, Монголын нууц товчоо хүндэтгэн залах арга хэмжээнүүдийг зохион байгуулан нийт 1934 хүнийг хамруулав. 2 сарын 03-ны өдөр “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулав. Тус өдөрлөгөөр номын үзэсгэлэн гаргаж, гэрээр ном олгох тасагт карт нээж ном олгон, Америкийн төвийн үйл ажиллагаа, цахим уншлагын тасгийн танилцуулга хийв.

Жаргалант сумын 1 дүгээр сургуультай хамтран “Монголын уламжлалт зан үйлээс суралцъя” сарын аяныг зохион байгуулах ажлын хүрээнд ёс заншлын холбогдолтой сэдэвчилсэн номын үзэсгэлэн, 7 дугаар ангийн сурагчдын дунд “Монгол ардын тоглоом наадам ном хэвлэлийн хуудаснаа” сэдэвт өглөөлгийг тус тус зохион байгууллаа.

Прогресс сургуулийн багш нар, Нийтийн номын сангийн гэрээр ном олгох тасаг, уншигчдын их танхимын номын санчид хамтарч “Ном унших сайхан” сэдэвт номын хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Өдөрлөгт Нийтийн номын сангаас шинэ номын үзэсгэлэн гарган сурталчилж уншлага болон үйлчилгээний талаар судалгаа

авч ажиллав. Номын сан нь Бодит хаяг буюу гадаад IP хаягтай болсноор Интернетийн сүлжээтэй бол орон зайг үл хамааран <http://103.242.46.108/> холбоосоор орж хайлт хийх боломжтой боллоо.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын дагуу осол гэмтлээс сэргийлэх өдрүүдийн хүрээнд 2017 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс 02 дугаар сарын 28-ныг хүртэл “Хүүхдийн түлэгдэлт-Эцэг, эхийн хариуцлагаас” уриан дор сарын аяныг төлөвлөгөөний дагуу 5 өрхийн эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудтай хамтран аймгийн төвийн 14 цэцэрлэгийн эцэг эхчүүдэд түлэгдэлт өвчнөөс урьдчилан сэргийлэх, түлэгдлийн үед анхны тусламж зөв үзүүлэх, амны хөндий, гарын ариун цэвэр хэрхэн сахих талаар сургалтыг зохион байгууллаа

2017 оны 2 дугаар сарын 2,3-ны өдрүүдэд Ховд дулааны станцын 99 ажилчдад халдварт бус өвчлөлийн шалтгаан, урьдчилан сэргийлэлт, эрүүл зохистой хооллолт, архи, тамхины хор хөнөөл болон ходоодны хеликобактер, элэгний В, С вирусаас урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээний талаар мэдээлэл өгсөн сургалт зохион байгуулж байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэв. Мөн цаашид энэ чиглэлээр 8, 9, 10 дугаар цэцэрлэгийн багш ажилчид, хорих ангийн ажилчид албан хаагчдад хийхээр төлөвлөөд байна. Мөн Дэлхийн зөн Ховд орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр, өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран “Залуу гэр бүлд эрүүл мэндийн боловсрол олгох” сургалт зохион байгуулж нийт 100 залуу гэр бүл оролцсоноор халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, халдварт өвчин, БЗДХ, өвчлөлийн талаар зохих мэдлэгтэй боллоо.

Норвегийн тусламжийн байгууллагын ЭМАШТҮБ 2 төслийн санхүүжилтээр “Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүй” сэдэвт 2 өдрийн сургалтад Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн албан хаагчид хамрагдаж эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургагч багшаар бэлтгэгдлээ. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн бүтэц үйл ажиллагааны стандартын төслийн саналыг өрхийн эрүүл мэндийн төвүүдэд танилцуулж, саналыг нэгтгэн Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тусламжийн газарт хүргүүлэв.

Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс томуу, томуу төст өвчний мэдээг 7 хоног бүр авч, Халдварт өвчин судлалын үндэсний төвд тухай бүр нь мэдээлсэн. ХӨСҮТөөвөөс улирлын товлолын вакцины татан авалтыг хийж 16 сум, 6 өрх, БОЭТөвд товлолын вакцины сарын хэрэглээг нийлүүлсэн. Томуу, томуу төст өвчин, халдварт өвчин, зооноз өвчний мэдээг бэлтгэн МХГ, ЗДТГ, БОЭТ, СЭМТ, ӨЭМТ-д хүргүүлж холбогдох дарга мэргэжилтнүүдийг мэдээллээр ханган ажиллаж байна.

**Биеийн тамир спортын чиглэлээр:** Биеийн тамир спортын газрын даргын баталсан 2017 оны сургалт бэлтгэлийн хуваарийн дагуу Үндэсний бөх, Жүдо, Чөлөөт, Самбо бөх, Бокс, Таеквондо, Волейбол, Сагсан бөмбөг, Хөнгөн атлетик, зэрэг спортын төрлүүдээр 550 гаруй тамирчид бэлтгэл сургуулилтанд хамрагдаж байна

Ховд аймгийн Биеийн тамир спортын газрын түүхт 70 жилийн ойн арга хэмжээ энэ онд тохиож байгаа бөгөөд уг арга хэмжээний хүрээнд Бөхийн чуулга барилдааныг 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж, тэмцээнд 17 сум, Жаргалант сумын 7 сургуулийн 8-17 насны 600 гаруй тамирчид 277 багц медалийн төлөө жүдо, самбо, чөлөөт бөхийн төрлөөр хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөв. Аймгийн 2017 оны ширээний теннисний аварга шалгаруулах тэмцээн Ховд хотноо 2 дугаар сарын 4-5-ны өдрүүдэд амжилттай явагдаж өндөрлөлөө. Мөн Мөсний сурын аймгийн аварга шалгаруулах тэмцээн 02 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулагдсан бөгөөд тэмцээнд нийт 60 гаруй тамирчин оролцсон байна.

Тэшүүрийн аймгийн аварга шалгаруулах анхдугаар тэмцээн, насанд хүрэгчдийн Волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээн мөн Алтан унжлагат хэмээх гал тахиа жилийн сар шинийн баярт зориулсан Үндэсний бөхийн барилдааныг тус тус зохион байгуулав.

**Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн чиглэлээр:** Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолын дагуу Осол гэмтлээс сэргийлэх өдрийн хүрээнд “Хүүхдийн түлэгдэлт-Эцэг эхийн хариуцлагаас” аяныг 2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс 03 дугаар сарын 15-ныг хүртэл Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулж байна. Аймгийн БОЭТ-ийн Гэмтлийн тасагт 2012-2016 онуудад түлэнхийн оношоор хэвтэн эмчлүүлсэн 217, амбулатороор 256, нөхөн сэргээх хагалгаа хийлгэсэн 26, нийт 499 хүн эмчлүүлснээс 0-5 насны хүүхэд 162 байгаа бөгөөд түлэгдэлд өртсөн хүүхдүүдийн ихэнх нь Хятад улсад үйлдвэрлэсэн цахилгаан тогоонд түлэгдсэн байдаг. Энэхүү аяны хүрээнд залуу эцэг эхчүүд болон хүүхэд харах үйлчилгээний төвийн ажилчдад бага насны хүүхдийн түлэгдэлтийн шалтгаан, нөхцөл, хор уршгийг танин мэдүүлэх, түлэгдэлтээс урьдчилан сэргийлэх талаарх эцэг эх, цэцэрлэгийн багш, сурган хүмүүжүүлэгч нарын мэдлэг хандлагыг өөрчлөх зорилгоор “Хүүхдийн түлэгдэл-эцэг эхийн хариуцлагаас сургалтыг зохион байгуулж сургалтанд 80 хүн хамрагдав.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор хаврын хурдан морины уралдаан үсэргээ, сунгааг зохион байгуулахгүй байх үүрэг чиглэлийг сумдын Засаг дарга, аймгийн уяачдын холбоонд хүргүүлэв.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.5 дахь заалтын дагуу авлигатай тэмцэх газартай хамтран “Хүүхдийн шударга байдал-2016” судалгааг онлайнаар зохион байгуулж Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн 7-11 дүгээр ангийн сурагчдын төлөөлөл 500 сурагчийг хамруулав.

Оюуны бэрхшээлтэй хүүхдүүд болон тэдний эцэг эх, хамтран ажиллагсад, сайн дурын ажилчдыг нэг дор цуглуулан пара олимпд оролцуулан тэднийг хооронд нь холбох, амжилт бүтээл, туршлагаасаа хуваалцах боломжийг олгох, тамирчдыг хөдөлгөөний болон танин мэдэхүйн чадваруудаа хөгжүүлэх, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх багаар ажиллахад сургах зорилгоор зохион байгуулагддаг баруун бүсийн хоёрдугаар “Тусгай олимп” Говь-Алтай аймагт 2017 оны 01 сарын 30-наас 02 сарын 01-ныг хүртэл баруун 5 аймаг Баянхонгор, Өвөрхангай аймгуудыг оролцуулан нийт 5 төрлөөр 150 гаруй тамирчид, хамтран ажиллагсадыг оролцуулан амжилттай зохион байгуулагдлаа. Тус олимпоос Ховд аймгийн баг тамирчид нийт 11 медаль хүртэж амжилттай оролцов.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудлаарх эрх зүйн орчны шинэчлэлт, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн төсөл боловсруулагдаж байгаатай холбогдуулан эцэг эх, иргэдийн төлөөлөл болох 50 хүн оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж хэлэлцүүлэгээс гарсан саналыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүллээ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/328 дугаар тушаалыг хэрэгжүүлж гэр бүлийн болон бусад орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэн ажиллах талаар сумдад чиглэл өгч ажиллаа.

Аймгийн Засаг даргаас олгодог бүтэн өнчин хүүхдийн “Гэрэлт-Ирээдүй” тэтгэлэгт 2017 онд шинээр хамрагдах хүүхдүүд болон 0-2 насны хүүхдийн эрсдэлт нөхцөл байдлын судалгааг хэрхэн яаж авах чиглэлийг сумдад өгч аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас төлөөлөл оруулж хамтран ажиллах талаар хүсэлтийг хүргүүллээ.

Аймгийн Цагдаагийн газар, Дэлхийн зөн Ховд орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд үүрэг хүлээгчдийг чадавхижуулах сургалт мөн хүүхэд харах үйлчилгээ эрхэлж буй иргэдийн мэдлэгийг сэргээх, шинээр мэдээлэл өгөх, хүүхэд харах үйлчилгээний тайлан мэдээллийг ирүүлэх талаар нэгдсэн ойлголт, мэдээлэлтэй болгох, үр дүнтэй ажиллаж буй хүүхэд харагч нарын гэрээг сунгах зорилго бүхий тус тус сургалтыг зохион байгуулж чиглэл өгч ажиллалаа.

**Хөдөлмөр нийгмийн халамж, үйлчилгээний чиглэлээр:** Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний газрын дарга Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргатай үр дүнгийн гэрээ байгуулж, мөн байгууллагын нийт ажилтан албан хаагчидтай үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулав. Ажил сайжруулах тусгай төлөвлөгөө гаргаж, халамжаас хөдөлмөрт гэсэн уриатай халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт нь олгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажиллаж байна. Иргэдэд ажил үйлчилгээг хурдан шуурхай хүргэх зорилгоор байгууллагадаа угтах үйлчилгээг шинээр бий болгов.



Тайлант сард бичиг 9, явуулсан бичиг 36, иргэдээс амаар болон бичгээр нийт 8 өргөдөл хүлээн авч бүртгэл хяналтын карт хөтлөн, биелэлтийг тооцлоо. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг 1.484.500 төгрөгийн орлого орсон байна. Хөдөлмөр, Орчны эрүүл мэндийн институтээс ирүүлсэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хүний нөөцийн судалгааг нийт 104 байгууллагаас авч, судалгаанд төрийн байгууллагын-62, хувийн хэвшил-42 байгууллага оролцов.

Энэ сард сард нийт 50 ажил идэвхитэй хайгч иргэнийг шинээр бүртгэж, 145 иргэний мэдээллийг шинэчлэн, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд идэвхижүүлээ. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн LMIS программд бүртгэлтэй ажилгүй иргэд 2074 үүнээс эмэгтэй 1032, Аажил идэвхитэй хайгчдаас 118 иргэнийг ажлын байранд зуучлан оруулж, шинээр бий болсон 8 ажлын байрыг бүртгэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулан, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, үйлчилгээний хүрээнд ганцаарчилсан зөвлөгөөг 14 иргэнд өгөв.

Ганцаарчилсан зөвлөгөөнд 14 хүн хамрагдан, Зорилтот бүлгийн 8 иргэнийг ажлын байранд зуучилж, 4 аж ахуйн нэгж байгууллагатай ажил олгогчийг дэмжих арга хэмжээний урамшуулал олгох гэрээ байгуулан ажиллаа. Гадаадаас Монгол улсад 5 мэргэжилтэн авч ажиллуулах тухай 3 аж ахуйн нэгж, байгууллага хүсэлт ирүүлснийг дэмжиж, саналыг ХХҮЕГазарт албан тоотоор хүргүүлэв.

Алдарт эхийн одонд 1230.000.000, алдар цолтой ахмадын хөнгөлөлтөнд 17000.000, ахмадын “Насны хиши”-т- 249.850.000 санхүүжилтийг тус тус олгов. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд зорилтот бүлгийн 201 иргэн хамрагдаж халамжийн сангаас 3.897.100 төгрөгийг зарцуулж, Wais программд бүртгэж баталгаажууллаа.

Жаргалант, Эрдэнэбүрэн, Дөргөн, Мянгад, Мөст, Манхан зэрэг сумдын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх болон иргэдэд амьдралын итгэл үнэмшил төрүүлэх, хөдөлмөрийн дадал олгох, авъяасыг нь дэмжих зорилгоор “Гэгээн гарц” НҮТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлж халамжийн сангийн санхүүжилтээр 156 ахмад настанд 2.941.500 төгрөгийг, хөгжлийн бэрхшээлтэй 21 иргэнд 423.200 төгрөгийг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 20 өрхөд 430.000 төгрөгийг нийт 3.794.700 төгрөгийг тус тус зарцуулав.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний “Түр байрлуулан, асрамжлах” үйлчилгээг 0-9 насны 3 хүүхдийн хамт гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн өрхөд хууль хяналтын байгууллага, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран гүйцэтгэж 5 хоног хамгаалах байранд байрлуулан асуудлыг богино хугацаанд шийдвэрлэж, Нийгмийн халамжийн сангаас хоол хүнс, ахуйн хэрэглээний нийт 102.400 төгрөгийн дэмжлэг үзүүлэв.

2017 оны 02 дугаар сард хүнсний эрхийн бичгийн цаасан хэлбэрээр үйлчилгээ авдаг 360 өрхийн /том хүн 1158, хүүхэд 1051 /01-р сарын/ 21.885.500 төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Өрхийн мэдээллийн нэгдсэн санд аймгийн хэмжээнд 02 дугаар сарын 21-ны байдлаар шинэ төрсөн 141 хүүхэд бүртгэгдсэн байна.

Дэлхийн Зөн Ховд орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй 2017 онд хамтран ажиллах гэрээний дагуу Жаргалант суманд 300 өрхийг сонгон ажиллаж байгаа бөгөөд тухайн өрхүүдэд шат дараалсан сургалтуудыг зохион байгуулан бүлэг болж ажиллахын ач холбогдлыг таниулах, чадваржуулах, бүлгийн зохион байгуулалтанд оруулах, бүлгээр хамтран ажиллах үйл явцыг дэмжих, бүлэг болж ажиллах идэвхи санаачлагыг өрнүүлэх сургалтуудыг зохион байгуулж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 31 дүгээр тогтоолоор “Ахмад настанд насны хишиг” олгох журам батлагдсан. Уг тогтоолыг хэрэгжүүлж 2 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэн ахмад настнуудаа бүртгэж “Ахмад настанд насны хишиг” олгох батламж гардуулан 65-69 настай 990, 70-79 настай 1445, 80-89 настай 445, 90-ээс дээш настай 62 нийт 2942 ахмад настаны WAIS бүртгэл баталгаажиж санхүүжилт нь олгогдов.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төвд асруулж байгаа өөрийн тэтгэврийн мөнгийг зарцуулах чадваргүй асруулагчдын тэтгэврийн мөнгөний 70 хувийн зарцуулалтанд хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/09 дугаар тушаалаар баталж, хяналт тавих журмыг боловсруулав. Мөн “Би ажилсаг асруулагч” сарын аяныг санаачлан, уг аяны хүрээнд асруулагчдын өдрийн жижүүр хийх хуваарь, хөдөлмөр эрхэлдэг ХБИ-ийг урьж асруулагчдад яриа хийлгэх, хийсэн бүтээлийг нь танилцуулах, “Эрүүл агаар-Эм” өдөрлөг зохион байгуулж асруулагчдыг агаарт гаргах гэх мэт үйл ажиллагаа явуулав.

**Эрүүл мэнд, нийгмийн даатгалын чиглэлээр:** Тус хэлтэст 98 албан бичиг ирсэнээс 70 албан бичгийг холбогдох байгууллагуудад уламжилж 18 өргөдөл гомдол хүлээн авсанаас 13 өргөдлийг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэж, 5 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа байна. Даатгуулагч иргэдэд 256 архивын лавлагаа гаргаж хэлтсийн сарын ажлын тайлан, мэдээг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлж, цаг үеийн асуудлыг хэлэлцэн тодорхой шийдвэрүүд гарган биелэлтүүдийг тухай бүрт нь тооцон ажиллаж байна.

Тус хэлтэс нь 2 дугаар сард сайн дурын даатгалд 3844 даатгуулагчийн 200,3 сая төгрөгийн орлого, эрүүл мэндийн даатгалын 1365 даатгуулагчийн 35 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд эмчилгээ үйлчилгээний төлбөрт 680 сая, Мөст сумын сум дундын эмнэлэгт 8,8 сая, Булган сумын нэгдсэн эмнэлэгт 80,1 сая, хувийн хэвшлийн 5 эмнэлэгт 65,3

сая төгрөгийн санхүүжилт тус тус шилжүүлэв. 737 ажил олгогч 13008 даатгуулагч хамрагдаж, шимтгэлийн орлого 1,116 сая төгрөг төвлөрүүлэх тооцоотой ажиллаж байна. Мөн өндөр насны тэтгэвэртэй 7471 өндөр настанд 23858189,1 мянган төгрөг, тахир дутуугийн тэтгэвэртэй 1822 иргэнд 4183292,5 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэртэй 876 иргэнд 2125401,0 мянган төгрөг, цэргийн тэтгэвэртэй 216 иргэнд 1074984,1 мянган төгрөг, үйлдвэрийн ослын тэтгэвэртэй 45 иргэнд 145510,0 мянган төгрөгийг тус тус зарцуулав.

**Тав:Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хүрээнд:**

**Байгаль орчны чиглэлээр:** Аймгийн ЗДТГ, Ховд Их Сургууль, Тогтвортой хөгжлийн хүрээлэн, Дэлхийн байгаль хамгаалах сантай хамтран “Тогтвортой хөгжил ба сэргэн хөгжихүй” сэдэвт сургалт болж байгаль орчны салбарын удирдлагууд болон мэргэжилтнүүд оролцов. Сургалтаар хувь хүний хөгжил, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн илтгэлүүд тавигдаж хүрээлэн буй орчны бохирдол, экологийн хомсдлыг эрс бууруулахын сацуу хүний амьжиргаа болон нийгмийн шударга байдлыг хангах замаар эдийн засгаа хөгжүүлэх зүй зэрэг сонирхолтой илтгэлүүдийг хэлэлцүүлээ. “Сүрлэг алтайн чимэг, харах нүдний баясал минь” сургалт, сурталчилгааны ажлыг Цэцэг, Мөст, Дуут сумдын Засаг даргын тамгын газар, Сум дундын Ой анги, Ус, цаг уур орчны шинжилгээний газар, “Алтайн нүүдэлчин” ТББ-тай хамтран 2 дугаар сарын 13-17-ны өдрүүдэд зохион байгуулав. Сургалтаар байгаль орчны хууль тогтоомжийг ард иргэдэд сурталчлан таниулах, байгаль хамгаалах уламжлалт арга ухааныг түгээн дэлгэрүүлэх, сум орон нутгийн удирдлага, ард иргэдэд өнөөгийн мөрдөгдөж буй байгаль орчны чиглэлийн хууль тогтоомж, дүрэм журмын талаар мэдээлэл өгч агнуурын бүсийн сумдын менежмент хариуцагчдын тайлан, мэдээг иргэдэд хүргэж, 2016 оны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх, 2017 онд хамтран ажиллах ажлын төлөвлөгөөний төсөлд санал авах зэрэг үйл ажиллагааг зохион байгууллаа.

Хар нуур Ховд голын сав газрын захиргааны хамт олонтой хамтран 2 дугаар сарын 2-ны "Дэлхийн ус намгархаг газрыг хамгаалах тэмдэглэлт өдөр"-ийн хүрээнд Ховд Их Сургуулийн Байгаль шинжлэл технологийн сургуулийн Биологийн тэнхимийн ББШ-I, IV ангийн оюутнуудад тус өдрийг танилцуулах сургалт, танин мэдэхүйн "АХА" тэмцээн зохион байгуулж I, II, III байруудыг шалгаруулан шагнаж урамшууллаа.

Дарви сумын Мөнгөн аяга багийн Элс толгой устгалын цэгт 538 бөхөн, 20 хар сүүлтий сэг зэм, Булаг багийн Тайн тохой устгалын цэгт 165 бөхөн, Мөрөн багийн Хонгор толгой устгалын цэгт 591 бөхөн нийт 1294 бөхөн, 20 хар сүүлтийн сэг зэм, мөн Чандмань сумын Тахилт багийн Тэсгэний үзүүр устгалын цэгт 426 бөхөн, 2 хар сүүлтий, Баянхайрхан багийн Нурамт устгалын цэгт 209 бөхөн нийт 633 бөхөн, 2 хар сүүлтий сэг зэм устгасан бөгөөд хоёр сумын 5 устгалын цэгт нийт 1927 бөхөн, 22 хар сүүлтий сэг зэмийг устгав. Үхсэн бөхөнгийн 70% нь янзага, 28,7% нь шаргачин, 1.3% нь ооно эзэлж байна.

Цэцэг сумын Баян-Овоо багийн нутаг Хүрэн толгой, Ховд сумын Цагаан бургас багийн нутаг Хогийн худагт хууль бус алт олборлохоор ирсэн иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоож, хуулийг сурталчилан, хэрэгжилтийг хангаж ажиллав.

Газрын хэвлийн нөхөн сэргээлт чиглэлийн мэргэжлийн байгууллагын эрх авах зорилгоор дүгнэлт гаргуулахыг хүссэн “Мөнх цагаан сувд” ХХК, “Хавтаг богд” ХХК-иудын холбогдох материалтай танилцаж, дүгнэлтийг Байгаль орчин аялал, жуулчлалын сайдад хүргүүлээ.

2 дугаар сарын 7-ны өдөр Борт багийн иргэн Б, Дээд улаан говийн хадны хөндийгөөс хүний гавал, чарга хэлбэрийн мод гарч ирсэн байна гэж мэдээлсний дагуу сумын байгаль хамгаалагч Борт багийн малчин Т.Ариунболдтой хамтран Дээд улаан говийн Өндөр улааны хөлний хадны хөндийд очиж үзэхэд хөндийгийн ойролцоо хүний гавлын яс, Балжирын өтөгийн ар талын улааны энгэрт 20см-ын өндөртэй, 30см-ын урттай, 15см-ын өргөнтэй чарга хэлбэрийн углаарга бүхий мод байв. Тус 2 газрын солбицолын фото зургийг авч ойр хавийн айл өрхүүдээр орж энэхүү газрыг харж хамгаалж байх, дахиж ухаж гэмтээхгүй байх талаар сануулга өгөв. Малтсан хадны дээд болон хажуу талаас нь чулуугаар дарсан байсан энэ газруудад эртний хадны оршуулга байх магадлал өндөр байлаа. Сумын төвөөс уг хадны оршуулга нэг талдаа 30-35 км-т байгаа мэдээллийг сум орон нутгийн удирдлагууд болон сумын соёлын төв, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ховд Их сургууль, аймгийн Музей зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагуудад цаг тухайд нь мэдээлэв.

Аймгийн Засаг даргын тамгын газар, Жаргалант сумын ЗДТГазар, багуудын Засаг даргатай хамтран Жаргалант сумын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор сайжруулсан утаа бага гаргадаг, иргэдийн эдийн засагт хэмнэлтэй, стандартын шаардлага хангасан Векас 801, 107, 108 зуухыг иргэдэд нийлүүлж худалдан борлуулсан байна.

Монголын уламжлалт “Сар шинийн баяр”-ыг угтаж “Бүх нийтийн цэвэрлэгээ”-г хийв. Тус арга хэмжээнд 13 сумын 600 гаруй иргэд оролцож 112.2 тн хогийг хогийн цэгт хаяж, 70 гаруй айл өрхөд анхааруулга мэдэгдэх хуудас тарааж, 5 айл өрхөд 100,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллалаа.

Аймгийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх Цагдаагийн газрын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгаас Байгаль орчин аялал жуулчлалын газарт хандаж Жаргалант сумын Рашаант багийн нутаг дэвсгэрт байрлах Сангийн хэрэмний дээд талд Ховд хотын ногоон байгууламжийн Улиас модноос хууль бусаар огтолсон 9 ширхэг модны хэрэг, зөрчилд холбогдох шинжилгээ хийж, шинжээч томилох тогтоолд дурдсан асуулт болон холбогдох эрх зүйн баримтыг үндэслэн дүгнэлт гаргаж ажиллав.

**Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:** Манай аймгаас Улсын аварга малчин 5, Улсын аварга тариаланч 2, Аймгийн хошой аварга 3, аймгийн аварга малчин 37, аймгийн аварга тариаланч 5, аймгийн аварга фермерч 1 хүн төрж, салбар,

салбарын 9 алдартнаа тодруулав. Алтай сумын Алтангадас багийн малчин Адуучийн Батжаргал, Булган сумын Байтаг багийн малчин Даваагийн Дүгэржав, Мөст сумын Баянхайрхан багийн малчин Даваагийн Дашзэвэг, Чандмань сумын Жаргалан багийн малчин Дашдоржийн Нямгэрэл, Эрдэнэбүрэн сумын Хонгио багийн малчин Намдагийн Олонбаяр нар төр засагтаа хөдөлмөр зүтгэлээ үнэлүүлж “Улсын сайн малчин”-аар тодров.

Аймгийн хүнс, хөдөө аж ахуйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд зохион байгуулж, салбарын 2017 оны зорилго, зорилт, хийж хэрэгжүүлэх ажлын талаар зөвлөлдөж, сумдын МЭҮТ, МЭҮҮН-үүдтэй 2017 оны үр дүнгийн гэрээ байгуулав.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг зэрлэг амьтны халдварын тархалтанд хяналт тавих зорилгоор Дарви, Чандмань сумдад ажиллаж, хэрэгжүүлж байгаа ажилтай нь газар дээр нь очиж танилцан, заавар зөвлөмж өгч цаашид хийх ажлын талаар чиглэл өгөв.

Чандмань, Дарви сумдын устгалын цэгүүдэд 1927 толгой бөхөн, 22 толгой хар сүүлтийн сэг зэмийг цуглуулан устгав. Энэхүү ажлын хүрээнд аймгийн Засаг дарга Д.Галсандондог, аймгийн орлогч дарга Ш.Батсүх, Ч.Уранчимэг, аймгийн ХХАА-н газрын дарга Т.Баатарзориг, БОАЖГ-ын дарга Л.Батбаяр зэрэг албаны хүмүүс оролцсон ажлын хэсэг дээрхи 2 сумдад 2 хоног ажиллаж устгалын ажлыг эрчимжүүлэх, хяналтыг сайжруулах, цаг үеийн ажлын талаар 2 сумын иргэд, хөдөлмөрчидтэй уузалт хийлээ.

Мөн дээрхи сумдад дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын зөвлөх Английн хатан хааны “ROYAL” коллежийн доктор, профессор Эричард Кок, дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын монгол талын үндэсний зөвлөх доктор П.Болортуяа, улсын Мал эмнэлэг, үржлийн газрын гоц халдварт өвчин хариуцсан мэргэжилтэн С.Батхуяг, УМЭАЦТЛаб, Байгаль, зэрлэг амьтныг хамгаалах нийгэмлэг зэрэг байгууллагын мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оношилгоо, тандалт, дээж цуглуулах, зөвлөмж өгөх зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ.

Аймгийн хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтний зөвлөгөөнийг Дэлхийн зөн Ховд ОНХХ–тэй хамтран 2 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд зохион байгуулж 17 сумын мал эмнэлэг үржлийн тасгийн дарга, малын эрүүл мэнд хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн, Хувийн мал эмнэлэг үржлийн үйлчилгээний нэгжийн эмч, Ногоон алт, Малын эрүүл мэнд төслийн хөдөө сумууд дахь мэргэжилтнүүд, хүнс хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн, эмч нарын бүрэлдэхүүнтэй 131 хүн оролцож хөтөлбөрт тусгагдсан 33 төрлийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож үр дүнтэй сургалт болов. Сургалт аймгийн ЗДТГ-ын Хуралдааны их танхимд болж, нээлтэнд аймгийн удирдлагууд оролцон мэндчилгээ дэвшүүлж сургалтыг нээв. Тус сургалтаар аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажилгааны хөтөлбөр, Мал аж ахуйн талаар төрөөс баримталж буй бодлого, чиглэл, өнөөгийн байдал, аймгийн ХХАА-н салбарт хийгдэж буй арга

хэмжээ, 2016 онд хийсэн ажлын тайлан, 2017 оны зорилтын тухай болон хүний нөөцийн чадавхийг сайжруулах, шинэ болон дахин сэргэж байгаа өвчнүүдийн талаар чиглэл өгч мэдээлэл хийв.

Сумдын мал эмнэлэг, үржлийн тасгийн болон хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн мэргэжилтнүүдтэй байгуулах үр дүнгийн гэрээ, 2017 онд хийх урьдчилан сэргийлэх арга хэмжээний захиалга, лабораторийн шинжилгээний төлөвлөгөөг нэгж бүрээр нэгтгэн гаргав. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх захиалгат Шөвөг яр 350.0, ДХХ 1254.2 л, Колибактериоз 185.6 л, Галзуу өвчний 30.0 тун вакцинийг хүлээн авч хуваарьт сумдад олгов.

“Хаврын баяр-2017” үзэсгэлэн худалдаа 2 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд аймгийн төвд зохион байгуулагдаж Жаргалант, Алтай, Булган, Мөст, Чандмань, Зэрэг, Манхан, Мянгад, Буянт, Мөнххайрхан, Эрдэнэбүрэн, Дөргөн, Цэцэг сумдын нийт 116 орчим иргэн аж ахуйн нэгж оролцож, 119,0 сая орчим төгрөгийн борлуулалт хийгдэж хэрэглэгчид нэг дороос үйлдвэрийн үнээр бараа бүтээгдэхүүнээ худалдан авах боломж бүрдэв. “Шилдгийн шилдэг “Гранпри” шагналаар “Баясгалант Өндөр хөхий” ХХК, “Шилдэг оёмол бүтээгдэхүүн”-ээр “Буянт үйлийн шим” хоршоо, “Шилдэг махан бүтээгдэхүүн”-ээр “Хишиг Эрдэнэ баяжих” ХХК, “Модон эдлэлийн шилдэг бүтээгдэхүүн”-ээр “Нарсны үнэр” ХХК, “Гар урлалын шилдэг бүтээгдэхүүн”-ээр Булган сумын иргэн Ш.Батгэрэл, “Шилдэг гурилан бүтээгдэхүүн”-ээр “Бадамлах Оюу” ХХК, “Шилдэг сүүн бүтээгдэхүүн”-ээр “Мөст Алтайн хишиг” малчны хоршоо, “Тавгийн шилдэг иж бүрдэл”-ээр иргэн Ч.Оюунгэрэл, “Ургамлын гаралтай бүтээгдэхүүн”-ээр “Тахилгатын нуруу” ХХК, “Олон нэр төрлийн хүнсний ногоо болон боловсруулсан бүтээгдэхүүн”-ээр “Буянт нахиа” хоршоо, “Шилдэг зохион байгуулалттай оролцсон сум”-аар “Мөст” сум, “Үйлдвэр эрхлэгч шилдэг залуу”-гаар Жаргалант сумын иргэн Бат-Очир, Хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн”-ээр “Шинэ санаа буянт” нөхөрлөл, “Шилдэг органик бүтээгдэхүүн”-ээр “Гурван хайрханы дом” ХХК, “Чанарыг эрхэмлэгч байгууллага”-аар “Үр жимс” хоршоо тус тус шалгаран өргөмжлөл цомоор шагнуулж хөдөлмөр бүтээлээ үнэлүүлэв.

**Газрын харилцаа барилга хот байгуулалтын чиглэлээр:** Сумдын газрын даамал болон аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтнүүдийн 2016 оны үр дүнгийн гэрээг дүгнэж, 2017 оны үр дүнгийн гэрээ байгууллаа.

Рашаант багийн өрхийн эмнэлэгийн барилга, БОЭТ-ийн цусны салбар барилгын засварын ажил дуусаж улсын комисс хүлээн авлаа. Мянгад сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах ажлын хээрийн судалгаа, тодруулалт хэмжилтийн ажлыг сумын даамал болон холбогдох мэргэжилтнүүд хамтран хийж тус сумын багийн хил, өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, хадлан, тариалан, түүх соёлын дурсгалт газар, худаг, уст цэгийг хэмжин тодруулалт хийж багийн иргэдийн Нийтийн хурлаар хэлэлцүүлэн батлуулав.

Өмчилсөн газрын хэмжээ, хаягийн зөрчилтэй 21 иргэний хүсэлтийг хүлээн авч аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 55 дугаар тогтоолын

хэрэгжилтийг ханган аймгийн Засаг даргын захирамж гаргаж зөрчлийг арилгав. Мөн 2016 оны 13 дугаар сарын 13 өдөр 2 иргэний хүсэлтийг судлан үзэж газар эзэмших эрхийг шилжүүлэн газрын гэрээ, гэрчилгээг олгов. Аймгийн хэмжээний газрын дээрх болон доорх инженерийн шугам сүлжээний урт нийт худгийн тоог гаргаж ГЗБГЗЗГ-т хүргүүллээ.

### **Зургаа. Сумдын мэдээлэл**

**Жаргалант сум:** Сумын төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, 2016 оны ажил үйлсээрээ манлайлан ажилласан иргэдийг сумын 9 алдартнаар шалгаруулж хүндэтгэл үзүүлэн, багуудын ажлыг дүгнэж 2016 оны тэргүүний багийг шалгаруулж урамшууллаа.

Сумын мэргэжлийн анги бүлгийн бэлэн байдлын үзлэгийг 2 удаа зохион байгуулж, гамшгийн чиглэлээр 1 өдрийн сургалт явуулж, байгууллагын галын аюулгүй байдлыг хангах зорилгоор галын хор, гал унтраах багаж тоног төхөөрөмжийг шинэчлэв.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Онцгой байдлын газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран нийгмийн ажилтан болон холбогдох мэргэжилтнүүд оролцсон сургалт семинарыг 3 удаа зохион байгууллаа.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль шинэчлэгдэн хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан багийн Засаг дарга, нийгмийн ажилтан нар “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд үүрэг хүлээгчдийг чадавхжуулах” сургалтанд хамрагдав. Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хүрээнд багийн нийгмийн ажилтнуудад өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах сургалт зохион байгуулж, 12 багаас 150 өрхийг сонгон авч, өрхийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан хамтран ажиллаж байна.

Монголын уламжлалт цагаан сарын баярыг тохиолдуулан 12 багаас харъяалалгүй 1480 ахмад настанг хөдөлмөр, халамж үйлчилгээний хүндэтгэлд хамрууллаа. Улс, аймгийн тэргүүний тариаланч, аварга малчин, фермерүүдийн материалыг бүрдүүлж аймгийн ХХААХҮГ-т хүргүүлснээс сумаас “Улсын тэргүүний тариаланч” 1, аймгийн “Аварга тариаланч” 1, аймгийн “Аварга фермер 1 төрөв. “Хаврын өнгө 2017” үзэсгэлэн худалдааг аймгийн ЗДТГ, ХХААГ-тай хамтран зохион байгуулж, сумын үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч 57 иргэн аж ахуй нэгжийг хамруулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчилан ажиллав.

Газар шинээр эзэмших, өмчлөхөөр 45 өргөдөл хүсэлт ирж, 26 өргөдлийг шийдвэрлэж, газрын гэрчилгээ олгон цахим мэдээллийн санд оруулав. Жаргалант сумын Засаг даргын А/41 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 02 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд тус сумын 12 баг, албан байгууллагуудын дунд бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, 12

багийн 3151 иргэн, 60 аж ахуй нэгж, албан байгууллагын 400 гаруй ажилтан албан хаагчид хамрагдаж нийт 132 м<sup>2</sup> хог хаягдлыг ачиж зайлуулав.

**Алтай сум:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл хуралдаж, 2017 оны жилийн ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батлав. Монгол улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайд У.Хүрэлсүхээр ахлуулсан ажлын хэсэг Алтай суманд ажиллан, иргэдтэй уулзалт хийж, 10тн малын тэжээл, 1500ш пресс, 800 уут малын тэжээл, 49 өрхөд хүнсний болон ахуйн хэрэглээний зүйлс өгөв.

Алтай сумаас МУ-ын аварга малчин 1, аймгийн аварга малчин 5, аймгийн алдарт уяач 2 тодорч сумын ИТХ, ЗДТГ хүндэтгэл үзүүлэв.

Алтай сумын ЕБС-ын 1-5 дугаар ангийн сурагчдын дунд "БИД АНГИАРАА УРАН УНШИГЧ" уран уншлагын наадам, 9-12 дугаар ангийн сурагчдын дунд гар бөмбөгийн уралдаан тэмцээнийг зохион байгуулав. Хамт олны нийгмийн асуудал, ажилчдын ахуй амьдралд тус дэм үзүүлэх зорилгоор сургуулийн захиргаа аж ахуйн хамт олон санаачилж "НЭГ САНААЧЛАГА-НЭГ АЖИЛ" аяныг 7 хоногийн хугацаатайгаар зохион байгуулав.

**Булган сум:** Жижиг дунд бизнес эрхлэгчдийн дунд "Цагаан сар" хэлэлцүүлгийг зохион байгуулж цаг үеийн мэдээ мэдээлэл солилцов. "Минжийн сувд 2017" өвлийн цас мөсний баярыг зохион байгуулж тус баяраар жороо морины уралдаан, шагайн харваа, сурын харваа, мөсний бүжиг зэрэг уралдаан тэмцээнүүдийг явуулав. Сар шинийн баярыг тохиолдуулан Хүчит 64 бөхийн барилдаан зохион байгуулж сумын ажил мэргэжлийн аваргаа шалгаруулж алдаршуулав.

**Дөргөн сум:** Сар шинийн баярыг тохиолдуулан цагаан идээний үзэсгэлэн худалдаа зохион байгуулж бараа бүтээгдэхүүнээ нэг дороос үйлдвэрийн үнээр худалдан авах боломжийг иргэдэд бүрдүүлэв. Сумын нийт ахмад настангуудад насны хишиг олгож 185 ахмад настанд гарын бэлэг гардуулан хүндэтгэл үзүүлэв.

Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, багийн Засаг дарга, ЭМТ-ийн эрхлэгч нар сум багуудын айл өрхүүдээр орж, өвөлжилтийн бэлтгэл байдалтай танилцаж, Төр, засгийн болон аймаг орон нутгийн бодлого шийдвэрийн талаар цаг үеийн мэдээлэл өгч, ард иргэдийн хүсэл, санал бодлыг сонсов.

**Манхан сум:** ОНОС дэд төслийн хүрээнд бүрэн дунд сургуультай хамтран багш, ажилчдад 2 удаа, эцэг эх олон нийтийн төлөөлөлд 1 удаа сургалт зохион байгууллаа.

УИХ, Засгийн газрын гишүүн ХЗДХ-ийн сайдын болон аймгийн Засаг даргын ажлын хэсгийнхний ард иргэдтэй хийх уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтаар Хууль зүй дотоод хэргийн Сайд болон аймгийн Засаг дарга нар УИХ болон Засгийн газраас хийж хэрэгжүүлж байгаа бодлого, шийдвэр шинэчлэн



батлагдсан хууль, тогтоомж болон үйл ажиллагааны хөтөлбөрөө танилцуулж, цаг үеийн мэдээ мэдээллийг түгээж санал бодлоо солилцов.

Аймгийн Прокурор, Цагдаагийн газар, Шүүх болон аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс сумын ард иргэдэд 2016 онд хийж гүйцэтгэсэн болон 2017 онд хийж хэргэжүүлэх ажлаа тайлагнаж иргэдийн санал хүсэлтийг сонслоо.

2016 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгдэж, аймгийн орон нутгийн өмчийн газарт хөрөнгийн тайлан тушаав. Энэ үеэр төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны сургалт зохион байгуулагдав. Сумын ЗДТГ болон төсөвт байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргаж аудитаар баталгаажуулав.

Манхан сумын эрүүл мэндийн төв 4 их эмч, 22 ажилтан, нийт 26 орон тоотойгоор иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж, 02 дүгээр сарын 23-ны байдлаар 711 хүнд үзлэг, шинжилгээ хийв. Урьдчилан сэргийлэх үзлэгт 221 хүн хамруулсан ба эмнэлэгт 64 өвчтөн хэвтэн эмчлүүлж байна.

Товлолын дархлаажуулалтанд 2 сартайгаас 2 нас хүртэлх 14 хүүхэд хамрагдаж, 4 эх эсэн мэнд амаржуулж, түргэн тусламжийн 21 дуудлаганд үйлчиллээ. 0-5 насны хүүхдийг сар бүр үзлэгт хамруулж, хүүхдийн өсөлт бойжилтонд хяналт тавин ажиллаж байна. Хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдэд 210 нэр төрлийн эмээр үйлчлэв.

Төгрөг гол багийн Засаг даргатай хамтран Рашаант тавьтын айл өрхүүдээр орж гудамж талбайд ил муу ус асгасан 37 өрхөд мэдэгдэх хуудас өгч, их цэвэрлэгээний ажилд ЕБС-ийн 9-12 дугаар ангийн сурагчдыг хамруулж хогийг зохих цэгт асгав.

“Хаврын өнгө-2017” үзэсгэлэн худалдаанд 8 хүний бүрэлдэхүүнтэй оролцож 1.800.000 төгрөгийн борлуулалт хийгдэв. Сумын 18 хүнсний дэлгүүр, 3 цайны газарт хүнсний аюулгүй байдлын хяналт шалгалт хийж мэдээ тайланг холбогдох байгууллагад хүргүүлэв. Сум хөгжүүлэх сангийн зээлд 17 төсөл хэлэлцүүлснээс 11 төслийн 76.5 сая төгрөгийг батлуулж зээл хүсэгчтэй гэрээ хийхээр төлөвлөөд байна.

**Мөст сүм:** Багийн ИНХ-ыг зохион байгуулсан бөгөөд 2017 онд хийх ажлынхаа төлөвлөгөөний талаар болон хийж хэрэгжүүлж буй ажлынхаа талаар иргэдэд мэдээлэл өгч санал бодлыг нь сонсов.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг сумын иргэд, хөдөлмөрчидтэй хийх уулзалт хийж аймаг орон нутгийн бодлого шийдвэрийн талаар цаг үеийн мэдээлэл өгч, Засаг даргын 2016-2020 онд хийж хэрэгжүүлэх

үйл ажиллагааны хөтөлбөрөө танилцуулав. Мөст сумаас Монгол улсын аварга малчин 1, аймгийн аварга малчин 2, аймгийн алдарт уяач 2 хүн тодорч сумын ИТХ, ЗДТГ хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн.

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал 3 удаа хуралдаж тодорхой асуудлыг шийдвэрлэн ажилласан болно. Үүнд:

1. Сургуулийн түүхт 70 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх цаг хугацааг хэлэлцэж 2017 оны 8 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэхээр шийдвэрлэв.

2. Сургуульд олон жил үр бүтээлтэй ажилласан, одоо ажиллаж байгаа багш, ажилчид мөн бусад салбарт ажиллаж байгаа нийт 21 хүний материалыг хэлэлцүүлэн Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлэв.

3. ИТХ-аас 2017 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан Тэргүүлэгчдээс гарсан саналыг тусган батлуулж, мөрдлөг болгон ажиллаж байна.

Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийг шинэчлэн 18 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл ажиллахаар болов.

Сумын Улаан загалмайн хороог шинэчилж олонхийн саналаар нарийн бичгийн даргаар сум дундын Хүн эмнэлэгийн эрхлэгч эмч Ж.Пүрэвбаатар сонгогдон аймгийн Улаан загалмайн хороотой хамтран ажиллах гэрээг байгууллаа.

Сар шинийн баярт зориулсан хүчит бөхийн барилдааныг зохион байгуулж тус арга хэмжээний үеэр сумын салбар бүрт манлайлсан аваргуудыг тодруулан шагнаж урамшуулав. Тухайлбал сумын аварга малчин 11, ажил мэргэжлийн аварга 5, аймгийн алдарт уяач 2, сумын алдарт уяачаар 5 иргэн тус тус тодорлоо.

2016 оны жилийн эцсийн орон нутаг болон төсөвт байгууллагуудын санхүүгийн тайлан гаргаж Төрийн сангийн хэлтэст тушааж аудитаар баталгаажуулав. Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээг программд шивлээ.

Орон нутгийн татварын орлого өссөн дүнгээр эхний 02 сарын байдлаар 3926.0 мянга төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 3528.3 мянган төгрөг орж 89.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд шинээр 5 даатгуулагч хамрагдсан ба нийт 28 даатгуулагчийн 728.9 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалд 28 даатгуулагч хамрагдаж 1083.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлээр 5 байгууллагын 21965.9 мянган төгрөг, нийт 23783.9 мянган төгрөгийн орлоготой, 2 арилжааны банкаар 3 төрлийн тэтгэвэрт 100711.8 мянган төгрөг, тэтгэмжинд 1575,4 мянган төгрөг нийт 102,287.2 мянган төгрөг тавьж олгосон ба энэ сард тэтгэврийн сунгалт хөдөлгөөнийг 9 тэтгэвэр авагч хийлгэсэн байна.

Тэтгэвэр тогтоолт, олголтыг шалгах аяны хүрээнд сумын хэмжээнд 389 тэтгэвэр авагчдын хувийн хэрэг, материалыг аймгийн эрүүл мэнд, нийгмийн

даатгалын хэлтэст хүргүүлж хяналт шалгалтыг 2 дугаар сарын 1-21-ний өдрүүдэд хийсэн. "Хаврын баяр 2017" үзэсгэлэн худалдаанд 5 багийн 13 иргэн аж ахуйн нэгж оролцож, аймгаас шалгаруулсан 15 номинацид Шилдэг зохион байгуулалттай сумаар шалгарсан ба сүү цагаан идээний төрлөөр "Мөст алтайн хишиг" хоршоо тэргүүн байр эзэлж өргөмжлөл, цомоор шагнагдав.

ХАА-н удирдах ажилтан малын эмч нарын зөвөлгөөнд тасгийн мэргэжилтэн, хувийн мал эмнэлэгийн эмч нар оролцож 2016 оны ажлаа дүгнүүлж сумын МЭҮТасаг аймагт 2 дугаар байр, "Мөст Мөнгөн боорж" МЭҮН 1 дүгээр байр эзлэв. Сар шинийн баярыг угтаж сумын нийт ард иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжийг хамруулсан нийтийн цэвэрлэгээний ажил зохион байгуулав.

Газрын талаар 5 өргөдөл хүсэлтийг хүлээн авч 4 иргэнд өвөлжөө хаваржааны 0,3 га газрыг эзэмшүүлж гэрээ, гэрчилгээ олгож улсын бүртгэлд бүртгэж авав. ЛМ тодруулах праграмм хангамж нэвтэрсэнтэй холбогдуулан нийт 1200 нэгж талбарын хувийн хэргийг тулгаж бүх нэгж талбарт товъёог хийлээ

Аймгийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн болж тус тэмцээнд биеийн тамирын багш М.Алтанхуяг баг тамирчидтайгаа амжилттай оролцож 6 медаль хүртэв.

Сургуулийн нийгмийн ажилтан сурагчдын сургалт хүмүүжлийн талаар яриа таниулга хийв. Сургуулийн 70 жилийн ой энэ онд болох тул сумын удирдлагууд Улаанбаатар хотын нутгийн зөвлөл болон аймгийн Засаг даргад санал хүсэлт уламжилж үүний үр дүнд сургуулийн хичээлийн 2 байрыг засварлахаар шийдвэрлүүлэв.

Эмнэлэгийн урьдчилан сэргийлэх үзлэг 461 иргэнд, гэрийн идэвхтэй эргэлт 86 иргэнд, алсын дуудлага 8 иргэнд, сэргээн засах эмчилгээг 12 иргэнд, гэрийн дуудлага 18 иргэнд тус тус үзүүлж вакцины хамралт 100% хийгдлээ. Осол гэмтлээс сэргийлэх сургалтыг 2, эмнэлгийн ажилчдын дотоодын сургалтыг 2 удаа тус бүр зохион байгуулав.

Сумын "Бооржийн унага" уяачдын холбооны ээлжит хурал болж тус хурлаар холбооны бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж 2017 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгөө хэлэлцэн баталсан. Хаврын уралдааныг зохион байгуулахгүй байх талаар заавар зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

**Дөргөн сүм:** 2017 онд аймгийн сайн малчнаар Агваш багийн малчин Б.Дашням, аймгийн хошой аварга малчнаар Д.Самданцоодол нар, Сумын сайн малчнаар Агваш багийн малчин Я.Өлзийсүрэн, Л.Цэвээндарь, Д.Алтан-Од, Сээр багийн малчин З.Лхагвацэрэн, Д.Цэдэнбал, Ч.Очирсүрэн, Ө.Баясгалан, Аргалант багийн малчин Г.Бинъяа, О.Боргио, Өгөөмөр багийн малчин П.Цогбадрах нар тодорч сумын ИТХ, ЗДТГын хамт олон хүндэтгэл үзүүлж байр хүргэв.

Сар шинийн баярыг тохиолдуулан бүх нийтийн их цэвэрлэгээг, Дөргөнд үйлдвэрлэв цагаан идээний үзэсгэлэн худалдааг тус тус зохион байгууллаа. Сумын нийт ахмад настангуудад насны хишиг олгож өндөр настан А.Хорлоо,

Б.Дүүрэн, С.Тогтох нарын гэрт сумын удирдлагууд зочилж насны хишгийн хувийг хүндэтгэлтэйгээр гардуулан өгч сумын 185 ахмадуудад гарын бэлэг гардууллаа.

Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, багийн Засаг дарга, ЭМТ-ийн эрхлэгч нар Дөрвөн багийнхаа бүх айл өрхүүдээр орж, аймаг орон нутгийн шийдвэр болон цаг үеийн мэдээлэл өгч, ард иргэдийн санаа бодлыг сонсов.

**Мянгад сум:** Шинээр томилогдсон багийн Засаг дарга нарыг томилон батламжилж, үр дүнгийн гэрээ байгууллаа. Засаг даргын Тамгын газарт 22 албан бичиг ирснээс 4 хугацаатай бичиг байсан бөгөөд хугацаатай бичгийн шийдвэрлэлтийг хугацаанд нь гаргаж хүргүүллээ. Байгууллага, иргэдээс нийт 8 өргөдөл, гомдол ирсэн ба хариуг хуулийн хугацаанд өгч шийдвэрлэв.

Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд тэжээгчээ алдсаны тэтгэмжийг нийт 23 иргэнд олгож 3114,0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэврийг 79 иргэнд олгож 99420.0 мянган төгрөг, ахмад настанг асарч буй иргэн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмжийг нийт 44 иргэнд олгож 2552.2 мянган төгрөг, Жирэмсэн хөхүүл эхийн тэтгэмжийг 1113 иргэнд олгож 489,0 мянган төгрөг зарцуулав.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 27354,0 мянган төгрөг, Иргэний Сайн дурын даатгалд 74 иргэнээс 604.7 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалд 51 иргэнээс 1782.0 мянган төгрөг, ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлд 1 иргэнээс 78.1 мянган төгрөг нийт 29818,8 мянган төгрөгийн орлого оруулав. Тэтгэвэр тогтоолгох өргөдөл 5 иргэнээс, “Ажилласан жил тэтгэврийн даатгал нөхөн тооцох хууль”-ийн хүрээнд нэмэгдэл тооцуулах 3 иргэнээс тус тус хүлээн авч хувийн хэрэг бүрдүүлэн тэтгэвэр болон нэмэгдлийг аймгийн тэтгэврийн мэдээллийн баазад оруулж тогтоолт хийж баталгаажуулав.

Нийгмийн даатгалын хэлтсээс тэтгэврийн даатгалын санд 78223.1 мянган төгрөгийн санхүүжилт авч өндөр насны тэтгэврийг 281 хүнд буюу 7011.8 мянган төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэврийг 31 хүнд буюу 5726.7 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэврийг 61 хүнд буюу 11160.7 мянган төгрөг, ҮОМШӨ-ний сангаас 1 хүнд буюу 261.3 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг тус тус олголоо.

2 дугаар сард төрөлт 8, гэрлэлт 1, нас баралт 2, шилжин явсан 12, шилжин ирсэн 14 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэв. Эрүүл мэндийн төв нь энэ сард нийт 127 иргэнд амбулаторийн үзлэг хийж 54 иргэнийг хэвтүүлэн эмчилж, 29 алсын дуудлаганд явж, жирэмсний хяналтанд 11 эхийг, товлолтын дархлаажуулалтанд нийт 19 хүүхдийг хамруулан ажиллав.

Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх малчид, малчин өрх, мал аж ахуйн үйлдвэрлэл, зах зээлийн талаарх мэдээллийн цогц сан бий болгох

634 малчид, малчин өрхийн дэлгэрэнгүй судалгааг /өвөлжөө хаваржааны координат, малын тоо төрлөөр, хүн амын тоо нас хүйсээр, эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалд хамрагдсан байдал, холбоо барих утасны дугаар/ өрх бүрээр гаргаж аймгийн ХХААГ-т хүргүүлэв. Сумаас аймгийн аварга малчин 2, Сумын сайн малчин 5 хүн тодорч сумын ИТХ болон ЗДТГ-аас хүндэтгэл үзүүлж баяр хүргэв. Тус сумын газар зохион байгуулалтын ажлын төлөвлөгөөний дагуу аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтэнтэй хамтран сумын өвөлжөө, хаваржааны координатжуулах ажлыг зохион байгуулан ажиллав.

**Ховд сум:** Тус сумын Засаг даргын Тамгын газарт нийт 10 өргөдөл ирсэнээс тусламж хүссэн 5, асран хамгаалагч тогтоох 1 иргэний хүсэлтийн дагуу хуулийн хугацаанд шийдвэрлэв. Газар эзэмшихийг хүссэн 1, ажил хүссэн 1, асаргааны тэтгэмж хүссэн 1 өргөдөл шийдвэрлэх шатанд хүлээгдэж байна.

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид 2 удаа хуралдаж, 12 тогтоол шийдвэр гаргав. 2017 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” мөн 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж буй “Эрүүгийн хууль” “Зөрчлийн тухай” хуулиудын онцлог зохицуулалтын талаар төрийн албан хаагчид, ард иргэдэд сургалт зохион байгуулж сурталчлав. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл”-ийг байгуулан зөвлөлийн дүрэм, хийх ажлын төлөвлөгөөг батлуулав. “Бамбар” Хүүхэд харах үйлчилгээний байр, үйл ажиллагаатай танилцаж зөвлөмж, зөвлөгөө өгөх ажлын хэсэг ажиллав.

Сумын нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлөөс “Цэвэр агаар ба эрүүл мэнд” мөсний баяр, сумын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос төсөвт байгууллага, аж ахуйн нэгжүүдийн галч, үйлчлэгч, жолооч нарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр сургалтыг зохион байгуулж, АХА танин мэдэхүйн тэмцээнийг зохион явууллаа Сумын наадмын талбайн засварын тендерийг зарлах үнэлгээний хороо хуралдаж тендерийн баримт бичгийг боловсруулан 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн олон нийтэд хэвлэл мэдээллээр зарлав.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд холбогдох алба хаагчид хамрагдаж МЭҮТасаг, МЭҮНэгжүүд ХХААГазартай хамтран ажиллах гэрээ байгуулав.

12 жилийн бүрэн дунд сургуулийн сурагчдад томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 6 удаа зохион байгуулж тус сургалтанд давхардсан тоогоор 346 хүүхэд хамрагдав. Аймгийн БСУГ-аас зөвлөн туслах ажлын хэсэг ажиллан, сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагаа, “Цөм хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцтай танилцаж, сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг хэвийн гэж үнэлэв.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР